

ҮНЭТ ЦААС ГАРГАЖ САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох элс, шохойн чулууны орд бүхий талбайд хайгуул хийх, ашиглалт явуулах эрхийг олгосон тусгай зөвшөөрлүүдийг эзэмшдэг.

- Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Цогт” нэртэй газарт 24.9 га талбайд ашигт малтмал ашиглах 14949А дугаартай тусгай зөвшөөрлийг 2009 оны 06 дугаар сарын 23-ны өдөр олгожээ. Тусгай зөвшөөрлийн хугацаа 30 жил тусгай зөвшөөрлийн 2 дахь жилийн төлбөрийг 2010 оны 03 дугаар сарын 31-ны өдөр төлсөн байна.
- Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт Сайхан нэртэй газарт 31 га талбайд хайгуул хийх тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Уг тусгай зөвшөөрлийг ГУУКГ-ын даргын 2008 оны 966 тоот шийдвэрээр “Дарсилбет”ХХК-иас шилжүүлэн авсан байна. Тусгай зөвшөөрлийн анх олгохдоо 2009 оны 12 дугаар сарын 26-ныг хүртэлх хугацаагаар олгосон боловч ГУУКХ-ийн даргын 2010 оны 550 тоот шийдвэрээр тусгай зөвшөөрлийн хугацааг 2010 оны 12 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл 1 жилийн хугацаагаар сунгажээ. Ашигт малтмалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэхь хэсэгт заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар 2 удаа сунгуулах эрхийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгосон байдаг. Иймд мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан журмын дагуу холбогдох материалаа бүрдүүлэн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах боломжтой.

Үнэт цаас гаргагч нь дээрх 2 тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу эзэмшиж байгаа бөгөөд эдгээр тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж ажиллаж байгаа тул тусгай зөвшөөрөл цуцлагдах ноцтой шалтгаан байхгүй байна.

Төслөөр баригдах үйлдвэр нь бүрэн шаталттай, үнслэгийг сорох тусгай төхөөрөмжтэй орчин үеийн технологитой тул байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай экологийн цэвэр үйлдвэрлэл юм. Энэ нь хууль эрх зүйн хувьд ямар нэгэн эрсдэлгүй байх эерэг талтай.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь доорх хуулиудын хүрээнд зохицуулагддаг. Үүнд:

- Авто тээврийн болон өөрө явагч хэрэгслийн албан татварын хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай
- Ашигт малтмалын тухай
- Байгаль орчиныг хамгаалах тухай
- Барилгын тухай хууль
- Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах хууль
- Гаалийн тухай
- Геодез зураг зүйн тухай
- Даатгалын тухай
- Компанийн тухай хууль
- Нийгмийн даатгалын хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай
- Үнэт цаасны зах зээлийн тухай
- Үйлдвэрчний эвлэлүүийн эрхийн тухай
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай
- Хөдөлмөрийн тухай хууль
- Стандарчлал тохирлын үнэлгээний тухай
- Татварын хууль
- Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай
- Эрчим хүчний тухай хууль